



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Тайлан хянасан:

Төсвийн төвлөрүүлэн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА...../У.БОЛДХҮҮ/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....
(огноо)

Тайлан гаргасан:

Төсвийн Шууд захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА...../Б.ТӨРХҮҮ/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

(огноо)

.....

ХЭНТИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<p align="center">ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/ ,УБЕГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө.</p>							
<p align="center">Зорилт1.Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.</p>							
1.1	Хэлтсийн шинэ байрны агааржуулалтыг сайжруулах /үйлчилгээний заал, архив/ болон гадна талбайн тохижилт ногоон байгууламжийг бий болгох.	-	Ажлын гүйцэтгэлийн хувь	0	100	Хэлтсийн шинэ байрны агааржуулалтыг сайжруулах агаар сэлгэлтийн системийн ажлыг барилгын гүйцэтгэгч “Мандалконстракшн” ХХК уулзалт, архивын ерөөнүүдэд агааржуулалтын хоолойг стандартын дагуу хийж нөхцөл байдлыг сайжруулсан Хэлтсийн байрны гадна талбайд 100 ш мод бут суулгаж , цэцгийн мандал хийж цэцэг үрслүүлсэн.	100
1.3	Тоон гарын үсэг олгох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах .	-	-Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн хувь	40	60	Тайлангийн хугацаанд аймгийн хэмжээнд 9780 иргэний хүсэлтээр тоон гарын үсэг олгоод байна. Үүнээс иргэний үнэмлэхэд 4424, мобайл апп-д 5356 тоон гарын үсэг олгосон. Тоон гарын үсэг олгож эхэлснээс хойш нийт 45807 иргэнд тоон гарын үсэг олгосон бөгөөд олговол зохих иргэдийн 83.9 хувьд нь олгосон байна. Цахим үйлчилгээ 24/7 булан ажиллуулж	100

						эхэлсэн бөгөөд улсын бүртгэлийн цахим бүртгэлийн машинаар энэ онд 1899 тоон гарын үсэг олгосон.	
1.4	Байгууллагын цахим хуудсыг тогтмол мэдээ мэдээллээр шинэчилж, нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллах. .	-	Цахим хуудаст байршуулсан мэдээ мэдээллийн тоо;	162	200	<ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын пэйж хуудсанд цахим хаяг /www.khentii.burtgel.gov.mn/ улсын бүртгэлтэй холбоотой 292 мэдээ мэдээлэл, зурган постер 203 , видео бичлэг 47, текст 42 байршуулсан. ➤ Албан хаагчид /гадаад паспортын бүртгэл болон шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоох, шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд бүртгэл хийсэн талаар гэх мэт/-ээр, 52 зурган постер, 16 видео контентыг өөрсдөө бэлтгэн байршуулсан. <p>Шилжилт хөдөлгөөн болон орон нутагт 3 төрлийн бүртгэлийн үйлчилгээг хүргэж байгаа талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл Aruukhan.mn, Хэнтий Житайм “Khentii.mn сайтад тус тус улсын ахлах бүртгэгч нар мэдээлэл хийж ярилцлага өгсөн.. Байгууллагын цахим /www.khentii.burtgel.gov.mn/ хаяг руу Пэйж хуудас дагагчийн тоо 1,2К, Хандалтын тоо 19752 байна.</p>	100
			Хандалтын тоо	11100	12000		

1.5	Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх.		Бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн тоо	0	1	Хэлтсийн улсын бүртгэлийн үйлчилгээнд сар бүр дүн шинжилгээ хийж байна. Улсын бүртгэгч нарын ажлын ачаалал өмнөх жилүүдтэй харьцуулахад сумдын улсын бүртгэгч нарынх 0.3 хувиар, тасгийн улсын бүртгэгч нарынх 4.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тасгийн улсын бүртгэгч нар үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг үнэлгээний төхөөрөмжөөр авч хэвшсэн. Тайлант хугацаанд 2709 иргэнээс сэтгэл ханамжийн үнэлгээ авахад 2337 маш сайн, 361 сайн, 11 дунд гэсэн үнэлгээ өгсөн байна. Эндээс үзэхэд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 99.5 хувьтай өндөр байна.	100
1.6	Хууль тогтоомж, дүрэм, журмын төсөлд санал боловсруулж хүргүүлэх.	-	- Төсөлд хүргүүлсэн саналын тоо	15	5	<ul style="list-style-type: none"> ➢ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх маягтын загварыг шинэчлэн боловсруулах төсөлд санал-3, УБЕГ-ын ХЭУБГазарт 2024.03.11-ний 1/117 албан бичгээр, ➢ Улсын бүртгэлийн байгууллагын 2024 оны эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгах санал-4, S.Enkhchimeg@burtgel.gov.mn ➢ Улсын бүртгэлийн байгууллагад Азийн хөгжлийн Банкны техникийн туслалцааны дэмжлэгтэй хэрэгжүүлэх төслийн хүрээнд хуулийн этгээдийн улсын 	100

						<p>бүртгэлийн шинэ системд тусгах санал-9, /2024.02.23 УБЕГ ХЭУБГазарт албан бичгээр/, ➤ УБЕГ-ын ХЭУБГазрын 2024 онд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр албан хаагчдыг дадлагажуулах сургалтын төлөвлөгөөнд тусгах сургалтын санал-1 нийт 17 саналыг тус тус холбогдох чиглэлийн газарт хүргүүлсэн.</p>
1.7	Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор контент бэлтгэж, түгээх.	-	Сурталчилсан мэдээ мэдээлэл, сурталчилгаа, контентын тоо	0	3	<p>Албан хаагчид зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор өөрсдөө биеийн давхцахгүй өгөгдлийн иргэний үнэмлэх сунгалт-1, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар -1, Хэлтсийн албан хаагчдын “Авлигын эсрэг НЭГДБЕ” уриатай контент видео-1 тус тус нийт 3 контент бэлтгэж, цахим орчинд түгээн тархаасан.</p> <p>Мөн улсын бүртгэлийн ажилтны өдрийг угтаж улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчилсан 16 контентыг улсын бүртгэгч нар өөрсдөө бэлтгэн цахим орчинд иргэн, хуулийн этгээдийг мэдээ мэдээллээр хангаж ажилласан. https://www.facebook.com/profile.php?id=100095359300358/</p>
Зорилт 2.Цахим бүртгэлийг хөгжүүлэх замаар улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлнэ.						

2.1	Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, бүртгэлийн үйлчилгээг иргэнд ойртуулах зорилгоор "Нээлттэй өдөрлөг"-ийг зохион байгуулах, явуулын үйлчилгээ үзүүлэх /зөөврийн тоног төхөөрөмжөөр/	-	Өдөрлөгт хамрагдсан иргэдийн тоо,	0	100	Төлөвлөгөөнд тусгагдсан нээлттэй өдөрлөгүүд зохион байгуулах ажлын хүрээнд Хуулийн байгууллагуудын дунд зохион байгуулдаг "Про боно" томоохон арга хэмжээнүүдэд оролцож 581 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Бор-Өндөр сумын улсын бүртгэгч нар Дархан, Баянмөнх сумдад, Батноров, Бэрх, Баян-Овоо, Норовлин сумдын улсын бүртгэгч нар хамтран Норовлин суманд нээлттэй өдөрлөг зохион байгуулав. Зөөврийн төхөөрөмж ашиглаж 24 иргэнд байгаа газар нь очиж үйлчилгээ үзүүлсэн нь иргэддээ хүрсэн хүртээмжтэй ажил болсон.	100
			Явуулын үйлчилгээ үзүүлсэн үйлчилгээний тоо	0	2		
1.2	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цогц үйлчилгээг сумдад хүргэх.	Орон нутгийн төсөв 2 сая	-Сумдад үзүүлсэн үйлчилгээний тоо,	537	550	Улсын бүртгэлийн хэлтэс нь ГХБХБГазартай хамтарсан баг гарч аймгийн 18 сум 5 тосгонд ажиллаж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 12 төрлийн үйлчилгээг үзүүлж, өмчлөх эрхийн гэрчилгээг газар дээр хэвлэж олгон 563 иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч цогц үйлчилгээг сумдад хүргэсэн.	100
2.2	Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэд и-монгол цахим систем, бүртгэлийн цахим машинаар түргэн шуурхай авах нөхцлийг бүрдүүлж ажиллах, сурталчлах.	-	- Цахим систем болон машинаар үзүүлсэн үйлчилгээний тоо	0	2	Иргэд бүртгэлийн үйлчилгээг цахим орчинд авах боломжийг бүрдүүлж үйлчилгээний зааланд и-монгол цахим порталаар өөртөө үйлчлэх хэсэг, хэлтсийн байрны үүдний хэсэгт Бүртгэлийн цахим	100

						<p>үйлчилгээ 24/7 булан гаргаж бүртгэлийн цахим машин байрлуулан иргэдэд 24 цагаар үйлчилгээ үзүүлж байна. Улсын бүртгэлийн цахим бүртгэлийн машинаар энэ онд 1899 тоон гарын үсэг олгосон.</p> <p>“E-mongolia” цахим системээр 140 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэх хүсэлт, гадаад паспорт 93, иргэний үнэмлэх 98 захиалж, E-business.mn хаягаар 1681 шинэ нэрийн хүсэлт, цахим гэрчилгээ-11, шинээр үүсгэн байгуулах хуулийн этгээдийн хүсэлт-3 ирснийг тус тус хугацаанд нь шийдвэрлэсэн</p> <p>Хэрлэн , Бор-Өндөр сумдад КИОСК цахим машинаас 8860 гаруй иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн лавлагааг тус тус олгосон.</p>	
2.3	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу эрхлэн хөтлөх.	-	Бүртгэсэн бүртгэлийн тоо;	17000	00 170	<ul style="list-style-type: none"> ➤ Иргэний улсын бүртгэлийн нийт 10875 бүртгэл,. ➤ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр: үйлчилгээ авах нийт 7977 мэдүүлэг хүлээн авч 7950 бүртгэл,. ➤ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2195 бүртгэлийг нийт аймгийн хэмжээнд 21020 улсын бүртгэлийг эрхлэн хөтөлсөн байна. 	100
Зорилт 3.Улсын бүртгэлийн мэдээллийн аюулгүй байдал, нэгдсэн сангийн нууцлалыг ханган, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.							

3.1	Улсын бүртгэлийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангаж, программ хангамж ашиглалтад хяналт тавих.	-	Хяналт тавьсан тоо	4	4	<ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын мэдээллийн сан, сүлжээний аюулгүй байдал гадны халдлагаас хамгаалах ажлын хүрээнд УБЕГ-аас хамгаалалт бүхий ROUTER 2 ш, хэлтсээс 16 оролт бүхий SWITCH 1 ш, CONVERTER 3 хос ширхгийг тус тус авч хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. ➤ Мөн улсын бүртгэгч нарын ашиглаж байгаа компьютер болон улсын бүртгэлийн программ хангамжид өөрчлөлт шинэчлэлийг давхардсан тоогоор 268 удаа тухай бүр холбогдон заавар зөвлөмж өгч, хяналт тавин ажилласан. ➤ УБЕГ-аас иргэн, эд хөрөнгийн цахим системд шинэчлэл, хөгжүүлэлт хийж байгаатай холбоотой /update/ 9 удаа хийн ашиглалтад оруулан хяналт тавин ажиллаж байна.. 	100
3.2	Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах.	-	Хуулийн хэрэгжилт, хувиар	100	100	<ul style="list-style-type: none"> ➤ Хэлтсийн төрийн захиргааны жинхэнэ албан хаагч 33 ажилтнаас 2023 оны “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”-ийг цаасан хэлбэрээр гаргуулан авч, сайтад бүртгүүлэн ХАСХОМ-ийн нэгдсэн тайланг хүргүүлсэн. ➤ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын 	

						<p>зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу Хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусгавар болсон 1 албан хаагчийн ХАСХОМ-ийг хугацаанд нь мэдүүлж ажилласан. Мөн хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчил үүсэн тухай мэдэгдэл 10 албан хаагчаас гаргуулан авч ажилласан.</p> <p>➤ МУИХ, АНСДИТХ-ийн сонгуульд итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах 186 албан хаагчдад төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийг танилцуулж нууцын баталгааг гаргуулан авч ажилласан. 2024 оны 11 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд Хэлтсийн дарга орон нутаг дахь тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын “ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн удирдах ажилтны зөвлөгөөнд хамрагдсан.</p>	
3.3	Улсын бүртгэл хөтлөх үйл ажилагаанд хяналт шалгалт хийх төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах.	-	-Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	60	100	<p>Хэлтсийн 2024 оны улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх 3 зорилт 12 арга хэмжээтэй төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Төлөвлөгөөний дагуу шалгалтаар Хэрлэн сумын 8 төрөл, шилжилт хөдөлгөөний нийт 1732 бүртгэлд шалгалт хийж, 40 зөрчлийн тэмдэглэл</p>	

						<p>үйлдэж улсын бүртгэгч нараар тухай бүр арилгах арга хэмжээ авч шийдвэрлэсэн.</p> <p>Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2482, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 560, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 350, архивын үйл ажиллагаанд 760 хувийн хэрэгт үзлэг шалгалтыг хийж нийт 4152 бүртгэлд шалгалт хийж үүнээс 45 бүртгэлийн зөрчлийг илрүүлж зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилласан .</p>	
3.4	<p>Улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх холбогдох арга хэмжээг авч ажиллах.</p>	-	<p>-Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд гарах зөрчлийг бууруулсан тоо;</p>	31	40	<p>Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн Б/297 дугаартай тушаалаар сумын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх олгосонтой холбоотойгоор эд хөрөнгийн эрх болон хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлаар 22 нэгжийн 32 улсын бүртгэгч нарт зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэл зөвлөмжийг боловсруулж 3 удаа бүртгэгч нарт хүргүүлсэн.</p> <p>Хуулийн хугацаанд иргэний үнэмлэх захиалах 16 нас хүрч буй ЕБС-ийн 3 сургуулийн нийт 265 сурагчдад зөрчлөөс урьдчилан сэргийлж сургалтыг зохион байгууллаа.</p> <p>Хэлтсийн албан хаагч,</p>	

						<p>улсын бүртгэгч нарт мэдээллийн сангийн аюулгүй ажиллагааг хангаж, системд хандах нууц үгийг сар бүр тогтмол шинэчилж ажиллах талаар 2 удаа зөвлөмж чиглэлийг өгч хэрэгжилтийг ханган хяналт тавьж ажиллаж байна. .</p> <p>Иргэний улсын бүртгэл хөтлөх, тоон гарын үсэг олгохдоо иргэн зөвхөн өөрийн биеэр ирсэн тохиолдолд бүртгэхэд онцгой анхаарч ажиллах талаар 24 улсын бүртгэгч нарт чиглэл өгч ажилласан.</p> <p>Хяналтын улсын байцаагчийн 38 дугаар албан шаардлагын дагуу 2024.07.01-ний өдөр улсын бүртгэгч нартай цахимаар холбогдож анхааруулга, чиглэл өгсөн.</p> <p>Төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд Улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх холбогдох арга хэмжээг авч ажиллаж зөрчлийг өмнөх оноос 23,4 хувиар бууруулж ажиллалаа.</p>	
3.5	Хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах.	-	-Хугацаандаа байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо -Тайлаганасан мэдээллийн мөнгөн дүн	158	159	➤ 2024 оны 10 дугаар сарын байдлаар 1.449.311.500 төгрөгийн төсөв батлагдан ирснийг Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтаар батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай 1 328 041 694 төгрөгийг зарцуулан нийт	100
				1 200 000 000	1 200 000 000		

						<p>121.269 805,9 төгрөгийг хэмнэж ажиллаад байна.</p> <p>➤ Улсын их хурлын сонгуул болон АСИНТХурлын сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд 162,293,500.00 төгрөг дээд шатны төсвийн захирагчаас шилжин ирснийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. Аймгийн засаг даргын А\277 тоот захирамжийн дагуу 3 000 000 төгрөгийн эрх тавиулах хүсэлтийг төрийн сангийн хэлтэст 1/311 тоот албан бичгээр хүргүүлээд байна.</p>
3.6	<p>Аудитын газар болон бусад байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж , мэдээ мэдээлэл, тайланг хугацаанд нь хүргүүлэх.</p>	-	<p>-Зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийн хувь</p>	0	80	<p>➤ Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2024 оны 10-р сарын байдлаар нийт 139 мэдээллийг хуулийн хугацаанд цахим болон мэдээллийн самбарт байршуулсан.</p> <p>➤ Төрийн аудитын тухай 6 дугаар зүйлийн 6.3.8 дахь зүйлийн 8.1 дэх заалтын дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлийн аудит хийлгүүлж ямар нэгэн зөвлөмж албан шаардлага аваагүй болно. УБЕГазраас санхүүгийн үйл ажиллагааны 2 чиглэл, шилэн дансны 1 чиглэл, УБЕГазрын санхүүтэй холбоотой тушаал 2 ирснийг үйл ажиллагаандаа мөрдлөг</p>

						болгон ажиллаж байна.		
Зорилт 4. Хуулиар олгосон тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ.								
4.1	МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, ажиллагааны гүйцэтгэлийн хувь	үйл	0	100	“Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд зориулсан программын сургалт”-ыг 2024 оны 06 дугаар сарын 19-ны өдөр УБЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу сургалтын багийн удирдлага дор зохион байгуулсан. Сургалтаар эцсийн байдлаар СНЖ-ыг хэвлэхэд сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа сонгогчдын тоо 52158, үүнээс нэмэгдсэн 851, хасагдсан 2382, иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлт 63, лавлагааг тусгасан байдлаар сонгогчдын тоо 49776 байв. Сонгуулийн ирц бүртгэлийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, хаалтын тайлангийн мэдээгээр Хэнтий аймгийн санал өгвөл зохих нийт 50112 сонгогчоос 34273 сонгогч саналаа өгч 68.39 хувийн ирцтэйгээр санал хураалтыг дуусгасан. Үүнд: түр хасав нэмэлт тэмдэглэгээ сэргээсэн 342, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар 552, хурууны хээгээр 33024, регистрийн дугаараар 355 сонгогчийн бүртгэлийн хуудас хэвлэсэн байна.	100
4.2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит	-	Төлөвлөгөөний хэрэгжилт,	үйл	0	100	Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд	

	сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг ханган ажиллах.		ажиллагааны гүйцэтгэлийн хувь			зориулсан программын сургалт"-ыг 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр УБЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу сургалтын багийн удирдлага дор зохион байгуулсан. Сургалтаар эцсийн байдлаар СНЖ-ыг хэвлэхэд сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа сонгогчдын тоо 51754, үүнээс нэмэгдсэн 2, хасагдсан 1786, иргэний улсын бүртгэлтэй холбоотой өөрчлөлт 40, лавлагааг тусгасан байдлаар сонгогчдын тоо 49968 байв. Сонгуулийн ирц бүртгэлийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж, хаалтын тайлангийн мэдээгээр Хэнтий аймгийн санал өгвөл зохих нийт 49973 сонгогчоос 31875 сонгогч саналаа өгч 63.78 хувийн ирцтэйгээр санал хураалтыг дуусгасан. Үүнд: түр хасав нэмэлт тэмдэглэгээ сэргээсэн 99, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар 601, хурууны хээгээр 30655, регистрийн дугаараар 520 сонгогчийн бүртгэлийн хуудас хэвлэсэн байна.	
Зорилт 5.Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.							
5.1	Аймаг, сумын ИТХ, ЗДТГ болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллах.	-	Хамтран ажиллах байгууллагын тоо	6	8	Хэнтий аймгийн ЗДТГ-аас албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор Засаг дарга Ц.Чогсомжав Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад 8,0 сая төгрөгийн өртөг бүхий / dell latitude 3440 маркын	100

						<p>нөтбүүк 1 ширхэг, dell суурин компьютер 1 ширхэг, hp laser 133 mfp принтер тус тус 1 ширхгийг бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн хөтлөх, бүртгэлийн үйлчилгээнд нэн шаардлагатай байгаа компьютер тоног төхөөрөмжийг шийдвэрлэж хүлээлгэн өгсөн.</p> <p>Хэнтий аймгийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Асуудлаас-Шийдэлд” арга хэмжээний дагуу хэлтсийн 1 албан хаагчийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулж 2,0 төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Тайлангийн хугацаанд төрийн болон төрийн бус 16 байгууллага /Тагнуулын хэлтэс, ШШГГ, АЗДТГ, ГБХХХГ, ГХБХБГ, ЦГ/-тай хамтран ажилласан. /Дэлгэрэнгүйг үйл ажиллагааны тайлангаас үзнэ үү/</p>	
5.2	Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх анхан шатны нэгжийн тоог нэмэгдүүлэх.	ADB төсөл -	-Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байгаа сумын тоо	3	6	<p>Анхан шатны нэгжид эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх 15, хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх 16-аар тус тус нэмэгдүүлж улсын бүртгэлийн 122 үйлчилгээг анхны нэгжээс үзүүлээд байна.</p>	100
Зорилт 6. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлнэ.							

6.1	Авилгын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх ажлыг цахим болон бусад хэлбэрээр зохион байгуулах.	-	Олон нийтэд хүргэсэн цахим мэдээллийн тоо	0	5	<p>Хэлтсийн цахим хуудаст тавигдсан 10 авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилсан зурган постер, мэдээ, мэдээллийг өөрийн цахим хуудаст түгээн тархааж, тогтмол идэвхжүүлэн ажиллаж байна</p> <p>Авилгын эсрэг хууль тогтоомжийг иргэн хуулийн этгээд, албан хаагчдад сурталчлах 4 удаа зурган постер мэдээлэл болон Хэлтсийн албан хаагчдын Авлигын эсрэг НЭГДБЕ уриатай видео контент-1 өөрсдөө бэлтгэн цахим хуудаст байршуулж түгээн тархаасан.</p> <p>“Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үүднээс Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй 4:7:10 сургалтад тогтмол хамруулж байгаа бөгөөд тайлант хугацаанд 10 удаа оролцсон.</p> <p>2024.10.22-ны “Шударга ёсны танхим” клубын гишүүд багш, сурагчид тус хэлтэст хүрэлцэн ирж албан хаагчидтай Авлигаас урьдчилан сэргийлэх, шударга нийгмийг бий болгох нь сэдэвт фокус ярилцлага зохион байгуулсан.</p>	100
			Зохион байгуулсан ажлын тоо	0	3		

.2	УБЕГ-ын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Хэлтсийн хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь	0	100	2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, даргын зөвлөлөөр хэлэлцэн баталсан. УБЕГ-ын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, iaac.mn цахим мэдээллийг ашиглан хооронд нь уялдуулан төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 11 арга хэмжээ, төлөвлөн боловсруулсан болно. Хэрэгжилтийг ханган 2024 оны жилийн эцсийн тайланг хугацаанд нь хүргүүлсэн. /Дэлгэрэнгүйг хэлтсийн 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны тайлангаас үзнэ үү/	100
Зорилт 7. Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, албан хаагчдын нийгмийн баталгааг хангана.							
7.1	Хэлтсийн 2024 онд зохион байгуулах сургалт, мэдээллийн болон үндсэн ажлаас гадуур хийгдэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх.	-	-Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	80	100	<ul style="list-style-type: none"> ➤ Тус хэлтсийн 2024 онд хэрэгжүүлэх нэгдсэн сургалтын 4 зорилт 33 арга хэмжээтэй төлөвлөгөө, үндсэн ажлаас гадуур хийгдэх ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах 78 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 1326 албан хаагчдыг хамруулаад байна. ➤ Иргэд олон нийт рүү чиглэсэн 36 удаагийн сургалт мэдээллийн арга хэмжээг 	100

						зохион байгуулж 656 иргэнд мэдээлэл хүргэж ажилласан./дэлгэрэнгүйг сургалтын тайлангаас үзнэ үү./	
7.2	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих.	-	-Үйлчилгээний стандартын хэрэгжилтийн хувь;	100	100	<ul style="list-style-type: none"> ➤ “Хөдөлмөрийн дотоод журам”, “Байгууллагын үйлчилгээний стандарт”, “Үнэлгээний төхөөрөмж ашиглах журам”-ын хэрэгжилтийг өдөр тутамдаа мөрдлөг болгон ажиллаж байна. ➤ Тайлант хугацаанд улсын бүртгэгч бүр үйлчилгээ үзүүлсэн 5293 иргэнээс үнэлгээ авч, үүнд маш сайн-4640, сайн-635 дунд-18, муу-0 гэсэн үзүүлэлт байна. ➤ Мөн хэлтсийн албан хаагчдын цаг ашиглалтын бүртгэл, чөлөөний хуудасны бүртгэлийг хөтөлж, хоцрох тохиолдолд талон цоолох ажлыг хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар зөрчил /ажлын цаг ашиглалт, үүрэг даалгаврын биелэлт/ гаргасан албан хаагч байхгүй. ➤ Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр жил бүр тухайн жилийн 1 дүгээр улиралд багтаан улсын бүртгэгч нарт албан бичгээр чиглэл, зөвлөмж хүргүүлсэн. Хэлтсийн албан хаагчдад 3 удаа ёс зүйн хариуцлага дээшлүүлэх чиглэлээр чиглэл 	100
			-Ёс зүйн арга хэмжээ авагдсан албан хаагчдын тоо;	3	0		

						зөвлөмж өгсөн. Бүх албан хаагчдын хувийн хэрэгт “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн хуудас” хавсаргасан. Ёс зүйн зөрчлийн тайлан мэдээг АЗДТГ-ын төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн. Ёс зүйн хорооны хурлаар 2 албан хаагчийг оруулж, ёс зүйн зөрчил гаргасан гэж үзэж сануулах арга хэмжээ авсан.	
7.3	Өргөдөл, гомдол, албан бичгийг хүлээн авч хуулийн хугацаанд хянан, шуурхай шийдвэрлэх.	-	- Ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо	25	20	Тайлангийн хугацаанд хэлтэст 36 өргөдөл, хүсэлт ирсний 29 нь иргэдээс, 7 хэлтсийн албан хаагчдаас, Ирүүлсэн 36 өргөдөл, хүсэлтийг холбогдох хууль журмын дагуу шуурхай 100 хувь шийдвэрлэсэн.Тайланг 11 удаа enkhzul.b@burtgel.gov.mn undraa@burtgel.gov.mn <u>цахим хаягаар хүргүүлсэн.</u> Иргэний улсын бүртгэлтэй холбоотой мэдээллийн санд нэмэлт өөрчлөлт оруулах 170 иргэний хүсэлтийг хүлээн авч холбогдох арга хэмжээ авсан. , гомдол гаргагчид хугацаанд нь хүргүүлсэн. УБЕГ-ын 1890 тусгай дугаарын утсанд 2 гомдол ирснийг шалгаж үзэхэд тоон гарын үсэг олголт болон шинээр хэвлэгдсэн иргэний үнэмлэхийн чип уншигдахгүй байгаа талаар байсан бөгөөд тухайн иргэдтэй холбогдож зөвлөгөөг өгч шийдвэрлэсэн	100

7.4	Хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллага, эрх бүхий этгээдэд улсын бүртгэлийн мэдээ, мэдээлэл хүргүүлэх.	-	-Хүргүүлсэн мэдээний тоо	8	8	<ul style="list-style-type: none"> ➤ 2024 оны байдлаар түр оршин суух иргэдийн мэдээг багийн Засаг дарга нараас авч нэгтгэн ИУБГ-т хугацаанд нь 3 удаа хүргүүлсэн. ➤ УБЕХ-ийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэгт заасны дагуу хууль хяналтын байгууллагын эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу албан бичгээр иргэний улсын бүртгэл 1730, хуулийн этгээдийн улсын бүртгэл 268, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 154 тус тус бүртгэлийн лавлагаа мэдээллийг олгосон байна. <p>Улсын бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тоон мэдээг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон нэгтгэж тухайн сарын 27-ны өдрийн дотор холбогдох чиглэлийн газруудад / ИУБГ-ын j.narantuya@burtgel.gov.mn цахим хаягаар тус тус хугацаанд нь 11 удаа хугацааг хоцроолгүй хүргүүлсэн</p>	100
7.5	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нар хариуцлагын даатгалд хамрагдах.	-	Даатгалд хамрагдах улсын бүртгэгч нарын тоо	0	3	УБЕГ-ын ЭХЭУБГазарт 2024.04.18-ний өдөр хуулийн этгээд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн хариуцлагын даатгалд хамрагдах 6 улсын бүртгэгчийн судалгааг гаргаж хүргүүлсэн байна. Холбогдох чиглэлийн газраас тодорхой хариу өгөөгүй байна.	

7.6	Шуурхай хурлаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг ханган хэрэгжилтийг тайлагнах /УБЕГ-ын даргын тушаал, шийдвэр, холбогдох чиглэлийн газрын зөвлөмж, чиглэл/	-	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	50	100	УБЕГ-ын удирдах ажилтны шуурхай хурлаас өгсөн үүрэг 20 үүрэг даалгавар, даргын зөвлөлийн 3 үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжилтийг ханган 23 удаа биелэлтийг гарган d.nandintsetseg@burtgel.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн. Тайлангийн хугацаанд УБЕГ-ын даргын 12 тушаал, УБЕГ-ын чиглэлийн газруудаас ирүүлсэн 31 чиглэл зөвлөмж, МУИХ-ын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан,
-----	---	---	------------------------------------	----	-----	--

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Хүрэх түвшин	Хэрэгжүүлсэн ажил	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5
“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
1.	Мэдлэг чадвараа дээшлүүлэх богино болон ахисан шатны сургалтад хамрагдах,	Мэргэшил дээшлүүлэх, ахисан шатны сургалтад хамрагдсан байна.	Олон улсын Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн сургуулийн Эрх зүйн эчнээ ангид суралцаж 52 кредит цагийг судалж суралцсан.	100%
2.	Туршлага судлах арга хэмжээ зохион байгуулах	Төлөвлөгдсөн 2 ажил хэрэгжсэн байна.	Бор-Өндөр сумын улсын бүртгэгч нар Дархан, Баянмөнх сумдад, Батноров, Бэрх, Баян-Овоо, Норовлин сумдын улсын бүртгэгч нар хамтран Норовлин суманд нээлттэй өдөрлөг зохион байгуулж, энэ хүрээнд улсын бүртгэгч нар	100%

			<p>туршлага солилцож, сайн туршлагыг бие биеэсээ суралцав.</p> <p>Хэлтсийн байранд 7 улсын бүртгэгчид бүртгэлийн программд дадлагажих, туршлага судлуулах ажлыг зохион байгуулсан.</p> <p>Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх авсан сумын 15 улсын бүртгэгч ажлын байран дээр дадлагажих сургалтыг зохион байгуулаад байна.</p>	
	Дундаж оноо			